



МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2025. 07.07 № 01/2269
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар баталсан "Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх захиргааны байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдсэн ХШҮ-ний дүгнэлт, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Дүгнэлт, зөвлөмжийн дагуу байгууллага тус бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах, төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст 2025 оны 11 дүгээр сард багтаан танилцуулахыг үүрэг болгож байна.

Зарим байгууллагууд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр (хоёр жил) дараалан хангалтгүй үнэлгээ авч байгаа үзүүлэлтэд анхаарч тухайн хариуцсан албан хаагч нарт холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах, байгууллагын зүгээс хийж хэрэгжүүлэхээр заагдсан арга хэмжээнүүдийг тухайн жилийн төсөвтөө багтаан шийдвэрлэж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт хуудастай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

11/24
шоёр

6125073126

12/9-12
З.Зүрчиг

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

Захирагч
О.Дуурал маргаач

Ташаанг хуралд
мөнгөний хэрэг,
нөхцөл мөнгөний
ЗДТГ 7/11/18

УБ-735
189



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ОРХОН АЙМАГ
2025 ОН

191

**ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/257 дугаар захирамжаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсгийн дарга:	Б.Ганзориг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	М.Жанболат	Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Л.Галсансайнхувьт	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	А.Өнөржаргал	Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
	Л.Түмэннаст	Архивын тасгийн дарга
	Б.Цэрэннадмид	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Баттүвшин	Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	С.Энхтүвшин	Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Ууганцэцэг	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Г.Эрдэнэбулган	Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Ядамсүрэн	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Г.Энхтуяа	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	М.Пүрэвмаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Баасансүрэн	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

НЭГ. ЗОРИЛГО

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон ил тод байдал, хүний нөөц, төсөв санхүү, өргөдөл гомдол, архив албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй И-Оффис систем ашиглалт, аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тусгай үзүүлэлтүүдэд хяналт шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар баталсан “Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу захиргааны байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн.



ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ажлын хэсгийн гишүүд хуваарийн дагуу байгууллага дээр очиж үйл ажиллагаатай нь танилцаж, газар дээр нь зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан.

Сумдын ЗДТГ, агентлагуудад удирдамж, хуваарийг хүргүүлэн ажилласан.

Удирдамжийг ажлын хэсгийн даргаар батлуулсан.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

I.I Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга

ДҮГНЭЛТ:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үндсэн 1, хамтран хэрэгжүүлэгчээр гаргах 1 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилт гаргах байтал гаргаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс үндсэн болон хамтран оролцогчоор нийт 21 арга хэмжээг хяналтад авхуулахаар цахим системд оруулсан боловч 4 арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл оруулаагүй байв. Хяналтад авсан арга хэмжээний хэрэгжилтийг цаасаар үзэхэд 19 арга хэмжээг хяналтад авч биелэлт гаргасан байв.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Хяналтад авбал зохих арга хэмжээг бүрэн хяналтад авч биелэлтийг тооцон ажиллах, хэрэгжилтийг тайлагнахдаа өссөн дүнгээр тайлагнаж, тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэх талаарх мэдээллийг тодорхой оруулж байх
- ✓ Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн талаарх мэдээллийг оруулж байх, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ ХШҮ-ний журамд заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлэх, шийдвэрлэлт хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх
- ✓ Хэрэгжилтийн тайланг цахим системд бүрэн оруулж байх
- ✓ Бодлогын баримт бичигт өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээнүүдийг тусгайлан бүрэн хяналтад авч тайлагнах, тайланг хугацаанд нь ирүүлж байх, хэрэгжилтийн хагас, бүтэн жилийн тайланг цахим санд хугацаанд нь оруулж байх, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэх мэдээллийг тодорхой оруулж байх.

I.II Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр бодлогын баримт бичгийг хяналтад авсан байдал, хэрэгжилт хангалтгүй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж эрчимжүүлсэн байдал, тайлагналт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь зэрэг үзүүлэлтүүдээр үнэллээ.

Хяналт шалгалт хийх явцад байгууллагууд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, зэргийг тусган хяналтад авч, хяналт шинжилгээ- үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу тайлагнаагүй, тайланг бичихдээ гол шалгуур үзүүлэлтийг тусгахгүй хэт үйл явдлыг нуршсан, хэрэгжилт хангалтгүй үйл ажиллагааг эрчимжүүлж, тухай бүр үүрэг даалгавар өгч, тэдгээрийг баримтжуулаагүй зэрэг зөрчлүүд ихэвчлэн гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Тайланг бичихдээ тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын хэмжээг өмнөх жилүүд болон тухайн жилээр салган тусгах
- ✓ Хангалтгүй үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх
- ✓ Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг арга хэмжээний биелэлттэй хамт хугацаанд нь тайлагнах

I.III Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байдал, хяналтад авсан байдал, хэрэгжилт хангалтгүй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж эрчимжүүлсэн байдал, тайлагналт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь зэрэг үзүүлэлтүүдээр үнэллээ.

Хяналт шалгалт хийх явцад байгууллагууд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, зэргийг тусган хяналтад авч, хяналт шинжилгээ- үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу тайлагнаагүй, тайланг бичихдээ гол шалгуур үзүүлэлтийг тусгахгүй хэт үйл явдлыг нуршсан, хэрэгжилт хангалтгүй үйл ажиллагааг эрчимжүүлж, тухай бүр үүрэг даалгавар өгч, тэдгээрийг баримтжуулаагүй зэрэг зөрчлүүд ихэвчлэн гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Хэрэгжилт бичихдээ тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын хэмжээг тайлагнах
- ✓ Төлөвлөсөн зарим арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарах
- ✓ Хагас болон бүтэн жилийн хэрэгжилт ирүүлэхдээ үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг заавал хамт ирүүлэх

II.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ


II.I Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт

1. Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан зүйл заалтын тоо (аймгийн хэмжээнд) Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим хуудсанд байршуулсан Монгол Улсын хууль, УИХ-ын болон байнгын хороодын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол болон хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын албан даалгавар нийт 151 тогтоол шийдвэрийн 262 зүйл заалтын биелэлтийг 2024 оны байдлаар нэгтгэж хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн.

2. Үнэлгээний дундаж дүн

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн (100%) 196, хэрэгжих шатандаа (70%) 47, хэрэгжилт хангалтгүй (30%) 8, хугацаа болоогүй 11 заалт байна.

Нийт 151 тогтоол шийдвэрийн 262 зүйл заалтыг графикаар харуулбал:



Аймгийн хэмжээнд нийт биелэлтийн дундаж 92.2 хувийн хэрэгжилттэй байна.

ДҮГНЭЛТ:

Монгол улсын хуулийн 2, УИХ-ын тогтоолын 2, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 6 заалт, ҮАБЗ-ийн зөвлөмжийн, Засгийн газрын тогтоолын 23, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 19, Засгийн газрын албан даалгаврын 1 заалтыг тус тус хяналтад авч хүргүүлснээс УИХ-ын тогтоолын 1, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 2, Засгийн газрын тогтоолын 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 4 заалтаас бусад заалтын хэрэгжилтийг цахим системд тайлагнаагүй байна. Зарим заалтын хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн заалтад заасан агуулгад тохирох хэрэгжилтийг оруулаагүй, найруулгын алдаатай, тухайн заалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөг бүрэн, оновчтой тодорхойлж оруулаагүй байна. Цахим системд хугацаандаа тайлагнаагүй учир зарим заалтын хэрэгжилтийн тайланг бодлогын хэлтсээр дамжуулан болон шууд холбогдон цаасаар авч аймгийн нэгдсэн тайланд тайлагнасан болно.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад буй заалтуудын хэрэгжилтийг бүрэн хугацаанд нь тайлагнаж хэвших, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулснаар гарч буй үр дүн, үр нөлөөг оновчтой тодорхойлон бүрэн оруулах
- ✓ Хэрэгжилт удаашралтай заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулснаар ямар үр дүнд хүрч байгаа талаар дүгнэн бичиж байх
- ✓ ХШҮ-ний журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан хэрэгжүүлэх талаар төлөвлөж буй арга хэмжээ болон хэрэгжилтийг нотлох баримтуудыг цахим системд хавсарган ирүүлж байх.

II. II Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр аймгийн ИТХ-ын шийдвэрийг хяналтдаа авч хэрэгжүүлж байгаа байдал, хэрэгжилтийг хугацаандаа цахим санд оруулсан байдал, 206 дугаар журмын дагуу үнэлгээ, товъёг хийж архивласан байдал зэрэг

202

үзүүлэлтүүдээр үнэллээ. Аймгийн ИТХ-ын 11 тогтоолыг хяналтад бүрэн авсан ч цахимд оруулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг цахим санд хугацаандаа, бүрэн оруулах
- ✓ Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээтэйгээ тохирсон хэрэгжилт гаргаж байх

III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

III.I Албан хэргийн хөтлөлт, архивын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

ДҮГНЭЛТ:

Засгийн газрын 2021 оны 226-р тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг явууллаа. Тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх хэрэглэхтэй холбоотой журам, стандартын хэрэгжилт сайн, хэвлэмэл хуудасны эхийг хянуулж зөвшөөрөл авч, стандартын дагуу хэвлүүлж ашиглаж байна. Монгол бичгээр албан хэргийг хөтөлж эхэлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам, стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах
- ✓ Тамганы дардсыг шинэчилж, журамд заасан хэмжээг баримтлан дахин хийлгэх
- ✓ Хэвлэмэл хуудасны бүртгэлүүдийг бүрэн хөтөлж, зарцуулалтын тайлан, мэдээг журамд заасан хугацаанд байгууллагын удирдлага болон Төрийн архивт ирүүлж хэвших
- ✓ Монгол бичгээр албан хэрэг хөтлөх ажлыг тогтмолжуулж, албан хаагчид өөрсдийн боловсруулж буй баримт бичгийг монгол бичгээр үйлдэж хэвших

III.II Хүний нөөцийн бодлогын ил тод байдалд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээг төрийн жинхэнэ албаны удирдах, албан тушаалд түр орлон гүйцэтгэгч ажиллаж байгаа эсэх, төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллаж байгаа эсэх, төрийн албан хаагчийн сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байгаа эсэх, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан тушаалын онцлог, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байгаа эсэх, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, хүний нөөцийн удирдлагын систем хөтлөлт, сул орон тоо гарсан тухай мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, зарлуулж байгаа байдал, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэл хөтөлж буй байдал, зэрэг үзүүлэлтүүдээр үнэллээ. Үнэлгээгээр хүний нөөцийн удирдлагын систем хөтлөлт дутуу байна.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” 04 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллах. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутам явцын хяналт-шинжилгээ хийж, жил бүрийн эцэст тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авах
- ✓ Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу Засгийн газрын баталсан журмын дагуу Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөны шалгуур үзүүлэлт тодорхой хэмжигдэхүйц болгох
- ✓ Төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан талаарх мэдээллийг албан хаагч нэг бүрээр хөтлөх ба энэ тухай хүний нөөцийн системд тухай бүр оруулж байх
- ✓ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөж тухай бүр нь баяжилт хийж, шинэчилж байх. Хувийн хэрэгт байх төрийн албан хаагчийн анкет бүрэн тэмдэглэл хөтлөх
- ✓ Төрийн байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 7 хоног бүрийн 4 өдөр зохион байгуулж байгаа 7*4*10 сургалтад хамруулах, сургалтыг цахим хэлбэрээр санаачилгатай ажиллах
- ✓ Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хөтөлж байх
- ✓ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам” 17 дугаар тогтоолын дагуу Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн нөөцийн

бүртгэл хөтлөх, Төрийн албанаас чөлөөлөгдөн сул орон тоо гарсан тохиолдолд энэ тухай мэдээллийг 7 хоногт төрийн албаны салбар зөвлөлд мэдэгдэж байх

III.III Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал, авсан арга хэмжээнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээг хугацаа хэтэрсэн, тайлан мэдээг хугацаандаа ирүүлсэн байдал, бүртгэл, тайлан, мэдээний чанар, өргөдөл, гомдлын программын ашиглалт, Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр үнэллээ. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирүүлдэг.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Засгийн газрын 11-11 төвөөс 7 гомдол, 70353511 төвд 509 өргөдөл, гомдол ирснээс 25 нь хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна. Иймд өргөдөл, гомдлыг яаралтай шийдвэрлэж, иргэнд мэдэгдэх тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, иргэний өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийгдсэн болон шийдвэрлэлтийн холбогдох баримт бичгийг цахим сан болон архивт хавсаргах
- ✓ Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах
- ✓ Цаашид өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийсэн ажлын тайланг ирүүлж иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээнд гомдлын дүн шинжилгээ хийхдээ өргөдөл, гомдлыг бууруулахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган ажиллах

III.IV Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ДҮГНЭЛТ:

Удирдамжийн дагуу мэдээлэл хариуцагч нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах, хуульд заасан нээлттэй мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангуулахтай холбоотой байгууллагын албан ёсны веб хуудас болон мэдээллийн

самбарт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллүүд байршсан эсэхийг хянаж, үнэлгээ өгсөн.

Байгууллагууд албан ёсны цахим хуудас ажиллуулж үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулж байгаа боловч сайтын бүтэц, дизайн, мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж, тухай бүр шинэчилж байгаа байдал харилцан адилгүй байна.

Мэдээллүүдийг хуульд заасны дагуу бүрэн байршуулаагүй, мэдээллийн цэсийг байршуулсан боловч дотор нь мэдээлэл тавиагүй, мэдээллийг шинэчлээгүй, зарим мэдээллийг хайж олоход хүндрэлтэй иргэд олох боломжгүй мөн санхүүгийн мэдээллийг зөвхөн Шилэн дансаар мэдээлж байгаа учир иргэд ойлгоход хүндрэлтэй өмнө онд өгсөн Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг нийтлэг зөрчлүүд гарч байна.

Энэ нь сайтын үйл ажиллагаа болон мэдээлэл байршуулах ажилтныг үүрэгжүүлээгүй, мэдээллийн ил тод байдалд байнгын хяналт тавьж ажиллахгүй байгаатай холбоотой байна. 2025 оны нээлттэй мэдээллүүд ороогүй. /Жич: Комиссын дүгнэлт, Авлигын мэдээлэл г.м/

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Мэдээллүүдийг хуульд заасны дагуу бүрэн байршуулах
- ✓ Байршуулсан мэдээллийг тогтмол шинэчлэх
- ✓ Сайтын үйл ажиллагаа болон мэдээлэл байршуулах ажилтныг үүрэгжүүлэх
- ✓ Мэдээллийн ил тод байдалд байнгын хяналт тавьж ажиллах

III.V Төсөв, санхүүгийн ил тод байдал, төлөвлөлтийн болон зарцуулалтын байдалд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах
- ✓ Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж төсвийг хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулах

III.VI Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дүгнэлт:

ДҮГНЭЛТ:

Аймгийн Засаг даргаас байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлж дүгнэсэн болно.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Үнэлгээний дүнг тооцож ажиллах
- ✓ Товч тодорхой байх
- ✓ Нотолгоонд суурилсан байх
- ✓ Шалгуур үзүүлэлт тодорхой хүрэх түвшиндээ хүрсэн эсэх
- ✓ Иж бүрэн байх
- ✓ Тайлан хамгаалалт хийгдсэн эсэх зэрэг үзүүлэлтүүдийн дүнгийн дунджаар үнэлгээг хийх

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд заагдсан холбогдох арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд анхаарах

III.VII Байгууллагын удирдлагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ДҮГНЭЛТ:

Удирдамжийн дагуу байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэрийн үндэслэлд үнэлгээ хийхдээ гаргаж буй шийдвэрийн хууль зүйн үндэслэл болон утга агуулга нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шийдвэр тус бүрээр хянаж, үнэлгээ өгсөн. Байгууллагын удирдлагын шийдвэрүүд хууль тогтоомжид нийцэж байгаа боловч дараах нийтлэг зөрчлүүд илэрч байна. Тухайлбал:

Байгууллагын удирдлага шийдвэр гаргахад тусгайлан эрх олгосон хуулийн зүйл, заалтыг үндэслэл хэсэгт дурдахгүй байна. Мөн шийдвэр гаргахдаа байгууллагын албан бичиг, иргэний өргөдөл зэргийг үндэслэж шийдвэр гаргах, тухайн шийдвэрийн агуулгад огт хамааралгүй хууль тогтоомжийн заалтыг үндэслэж шийдвэр гаргасан байна.

Иймд Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны актын агуулга ба хэлбэр, захиргааны актад тавигдах шаардлагыг бүрэн хангасан шийдвэр гаргахад онцгой анхаарах шаардлагатай. Шийдвэрийн хууль зүйн үндэслэл, тэргүү болон бичвэрийн агуулга нь хоорондоо уялдаагүй, зөрчилдсөн, эсрэг агуулгатай гарсан тохиолдлууд байна.

Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан хуулийн болон албаны үг хэллэгийг ашиглаагүй, хуулийн зүйл, заалтыг буруу хэрэглэх зөрчил түгээмэл байна. Тухайлбал: Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааг Төрийн албаны хуулиар зохицуулах, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, мөнгөн урамшуулал, тэтгэмж, буцалтгүй тусламжийг олгохдоо хууль зүйн үндэслэл, нэршлийг буруу тодорхойлсон байна.

Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, ажлаас чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрүүдэд ямар шалтгаанаар чөлөөлж байгаа, ямар зөрчил гаргасан, энэ үйлдэл нь ямар хууль тогтоомжийг зөрчиж байгааг тодорхой дурдаагүй байна. Мөн сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчид сахилгын шийтгэлтэй байх хугацаанд үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Захирамжлалын баримт бичгийн дугаарлалт давхардсан, эсвэл дутсан түүнчлэн хавсралтгүй тушаал, шийдвэрүүд цөөнгүй байна.

A/23 дугаар тушаал байхгүй.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Шийдвэр гаргах үйл явцыг тодорхой шат дараалалтай болгож, хууль зүйн үндэслэл, утга найруулга, албан хэрэг хөтлөлтийн хувьд хянаж, хуульд нийцүүлж гаргахад анхаарах шаардлагатай байна.

III.VIII И-оффис системийн ашиглалтын байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

Захиргааны байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны И-Оффис системийн ашиглалтад Хяналт-шинжилгээ үнэлгээг хийсний дүнд байгууллагууд аймгийн Засаг даргын Тамгын газартай холбогдон ажилладаг албан хэрэг хөтлөлтийн багц /ирсэн бичиг, явуулсан бичиг, өргөдөл гомдол/ системүүдийг хэвийн хэмжээнд ашиглаж байгаа бөгөөд байгууллага дотроо ашиглах системүүдийг тухайлбал баримт бичиг төлөвлөлт, үүрэг даалгавар, ажлын төлөвлөгөө гүйцэтгэлийн системүүдийг мөн архивын систем, байгууллагын, нэгжийн, ТЖАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний системүүдийг хангалтгүй ашигласан хэвээр байна.

Аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгавар болох байгууллагын ажилчдын ажлын цагийн бүртгэлийг төхөөрөмжөөр бүртгэн и-оффис системд

холбох ажил бүрэн хийгдсэн ч системд илгээж бүртгэлээ хөтлөөгүй байгууллагууд байсан бөгөөд хөтөлж ажиллахыг тухай бүрд сануулсан.

Мөн Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн №2024-163 тогтоолд дурдагдсан Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах үйл ажиллагаа хангалтгүй байна. Иймээс шаардлагатай зардлыг төсөвтөө тусан хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл Төрийн байгууллагын gov.mn нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчилж ажиллах, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д улирал бүр байршуулж дүгнүүлж ажиллахыг байгууллагуудын удирдлагууд болон холбогдох мэргэжилтэнд зөвлөсөн.

III.IX Аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

ДҮГНЭЛТ:

Хяналт шинжилгээ, үнэлгээг үүрэг даалгаврын хэрэгжилтийг 206 дугаар журмын дагуу үнэлгээ, товъёг хийж архивласан байдал, хэрэгжилтийг хугацаандаа И-Офисс системд оруулдаг зэрэг үзүүлэлтүүдээр үнэллээ.

ЗӨВЛӨМЖ:

- ✓ Үүрэг даалгаврын бүртгэл хөтлөх, цахим санд биелэлтийг хугацаандаа бүрэн оруулж байх, холбогдлох мэргэжилтнээс биелэлтийг нягталж, тодруулж программд оруулж байх
- ✓ Үүрэг даалгаврын биелэлт хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзэнгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаарх мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффисс программын дотоод эмайлаар мэдэгдэж байх

907

Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн, хүснэгтээр

№	Байгууллагын нэр	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ				Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ		Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ										Нийлбэр оноо	Дундаж оноо	2023 оны дундаж оноо
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Албан хэргийн хөтөлмөт, архивын хууль тогтоомжийн хэрэгжилт	Хүний нөөцийн борлогын ил тод байдал	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлаас авсан арга хэмжээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	Төсөв, санхүүгийн ил тод байдал, төлөвлөгөөний болон зарцуулалтын байдал	Төсвийн ерөнхийлөн захирагчас төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Байгууллагын удирдлагын шийдвэрийн хууль зүйн үндэслэл	И-оффис систем ашиглалтын байдал	Аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	Байгууллага бүрийн үйл ажиллагааны тусгай үзүүлэлтийн үнэлгээ			
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
20	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2.50	4.05	3.80	4.00	3.33	3.33	4.66	4.50	4.10	4.30	5.00	4.83	4.60	4.60	4.78	4.68	67.08	4.19	4.24

№	Захиргааны байгууллагын нэр	2023		2024		Өсөлт, бууралт, пунктээр
		Оноо	Эзэлсэн байр	Оноо	Эзэлсэн байр	
1	Статистикийн хэлтэс	4.86	1	4.84	1	-0.02
2	Орон нутгийн өмчийн газар	4.54	7	4.82	2	0.28
3	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	4.50	12	4.74	3	0.24
4	Биеийн тамир спортын газар	4.48	14	4.71	4	0.23
5	Хүнс, хөдөө аж ахуйн газар	4.32	18	4.67	5	0.35
6	Боловсролын газар	4.56	3	4.66	6	0.10
7	Татварын газар	4.51	10	4.66	7	0.15
8	Байгаль орчны газар	4.71	2	4.66	8	-0.05
9	Стандарт хэмжээ зүйн хэлтэс	4.50	13	4.66	9	0.16
10	Ус цаг уур, орчны шөвчилгээний төв	4.42	16	4.64	10	0.22
11	Соёл урлагийн, аялал жуулчлал, залуучуудын газар	4.41	17	4.60	11	0.19
12	Эрүүл мэндийн газар	4.48	15	4.58	12	0.10
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	4.53	9	4.54	13	0.01
14	Нийгмийн даатгалын газар	4.51	11	4.46	14	-0.05
15	Онцгой байдлын газар	4.55	5	4.46	15	-0.09
16	Мал эмнэлэгний газар	4.53	8	4.37	16	-0.16
17	Цагдаагийн газар	4.55	4	4.35	17	-0.20
18	Худалдан авах ажиллагааны газар	*	*	4.26	18	*
19	Хотын захирагчийн алба	4.23	21	4.22	19	-0.01
20	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	4.24	20	4.19	20	-0.05
21	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	4.17	22	4.16	21	-0.01
22	Улсын бүртгэлийн хэлтэс	4.11	23	4.14	22	0.03
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	4.54	6	4.09	23	-0.45
24	Шүүх шөвчилгээний хэлтэс	4.28	19	3.99	24	-0.29
25	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	3.16	25	3.91	25	0.75
26	Сум дундын ойн анги	3.75	24	3.67	26	-0.08

ГУРАВ. ХАРИУЦЛАГА

Аймгийн Засаг даргын 2022 оны А/750 дугаар захирамжаар баталсан “Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 12 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцно.

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2025-06-20

Орхон аймаг

д/д	Зорилт Үнэлгээ	Бүгд	Гүйцэтгэлийн зорилт							
			1	2	3	4	5	6	7	8
1.	Арга хэмжээний тоо	73	5	8	14	11	8	2	14	7
2.	6.2.1 буюу 100% ба түүнээс дээш	23	1	3	4	4	2		5	2
	95.0%	1							1	
	93.7%	1			1					
	90.0%	30	3	1	5	4	3	4	6	4
	80.0%	1					1			
	50.0%	8		2	3		1		2	
	30.0%	2			1		1			
	Хугааа болоогүй	7	1	2		3				
Ерөнхий үнэлгээ, хувь		Бүрэн хангалттай 87.6% буюу 4.38	92.5% буюу 4.63 ОНОО	87.1% буюу 4.08 ОНОО	78.1% буюу 3.91 ОНОО	95.0% буюу 4.75 ОНОО	78.8% буюу 3.94 ОНОО	93.3% буюу 4.67 ОНОО	88.2% буюу 4.41 ОНОО	93.3% буюу 4.67 ОНОО

ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОРИГТБАЯР

Ж.БААСАНСҮРЭН

М.ПҮРЭВМАА

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

Д/д	Зөвлөмж	Хэрэгжилт	Хувь
I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ			
1	Тайланг бичихдээ тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын хэжээг өмнөх жилүүд болон тухайн жилээр салган тусгах	Тайланг бичихдээ тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын хэжээг өмнөх жилүүд болон тухайн жилээр салган бичиж байна.	100
2	Хагас болон бүтэн жилийн хэрэгжилт ирүүлэхэд үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг заавал хамт ирүүлэх	Тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт хүргүүлж байна.	100
II. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР			
3	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад буй заалтуудын хэрэгжилтийг бүрэн хугацаанд нь тайлагнаж хэвших, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулснаар гарч буй үр дүн, үр нөлөөг оновчтой тодорхойлон бүрэн оруулах	Монгол Улсын Их Хурлын 2 тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоол, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмж, Засгийн газрын 16 тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 17-ийг хяналтад аван хэрэгжилтийг гарган хагас, бүтэн жилээр үр дүнг оновчтой тодорхойлон биелэлтийг гарган ажиллаж байна	100
4	Хэрэгжилт удаашралтай заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулснаар ямар үр дүнд хүрч байгаа талаар дүгнэн бичиж байх	Удаашралтай байгаа 1 заалтыг эрчимжүүлэх талаар холбогдох мэргэжилтэнд үүрэг болгон ажиллаж байна.	100
5	ХШҮ-ний журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан хэрэгжүүлэх талаар төлөвлөж буй арга хэмжээ болон хэрэгжилтийг нотлох баримтуудыг цахим системд хавсарган ирүүлж байх	Тайлангийн хэрэгжилтийн холбогдох нотлох баримтыг цахим системд оруулан ажиллаж байна.	100
6	Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг цахим санд хугацаандаа бүрэн оруулах	Тогтоол шийдвэрийн биелэлтийг иоффисид оруулж байна.	100
7	Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээтэйгээ тохирсон хэрэгжилт гаргаж байх	Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт хүрэх үр дүнг тооцон биелэлтийг тайлагнан ажиллаж байна.	100
III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН			
8	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны "Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай" 04 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллах. Сургалтын	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны "Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай" 04 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн	100

	хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутам явцын хяналт-шинжилгээ хийж, жил бүрийн эцэст хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авах	ажиллаж байгаа бөгөөд одоогоор байгууллагын 18 албан хаагчийг анхан, дунд, ахлах, эрхэлсэн сургалтад хамруулсан.	
9	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу Засгийн Газрын баталсан журмын дагуу Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь шалгуур үзүүлэлт тодорхой хэмжигдэхүйц болгох	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвараар гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжигдэхүйц байхаар байгууллагын төрийн захиргааны 21 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан бөгөөд тус тушаалын 6 дугаар хавсралтаар хагас, бүтэн жилийн тайланг, 8 дугаар хавсралтаар батлагдсан үнэлгээний хуудсаар үнэлсэн. Мөн төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулан биелэлтийг тооцон улирал бүр гарган үр дүнг нь тооцон ажилласан.	100
10	Төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан талаарх мэдээллийг албан хаагч нэг бүрээр хөтлөх ба энэ тухай хүний нөөцийн системд тухай бүр оруулж байх	Удирдлагын академиас зохион байгуулж байгаа төрийн албан хаагчийн эрхэлсэн түшмэлийн сургалтад-1, ахлах түшмэлийн сургалтад-1, төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад-4, төрийн албан хаагчийн анхан шатны сургалтад-12 албан хаагчийг амжилттай хамрагдан үнэмлэхээ авсан. Сургалтад хамрагдсан албан хаагчийн мэдээллийг тухай бүр нь хүний нөөцийн мэдээллийн санд тогтмол оруулан ажиллаж байна.	100
11	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг мөрдөж тухай бүр нь баяжилт хийж, шинэчилж байх. Хувийн хэрэгт байх төрийн албан хаагчийн анкет бүрэн тэмдэглэл хөтлөх	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журам"-ын дагуу байгууллагын 25 албан хаагчийн хувийн хэргийг хөтөлж тухай бүр нь шинэчлэн ажиллаж байна.	100
12	Төрийн байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, соёл гэгээрүүлэх чиглэлээр 7 хоног бүрийн 4 өдөр зохион байгуулж байгаа 7*4*10 сургалтад хамруулах, сургалтыг цахим хэлбэрээр санаачилгатай ажиллах	Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр "Ажлын байрны ёс зүй" сургалтад байгууллагын 22 албан хаагчийг хамруулсан. Мөн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа 7*4*10 сургалтад албан хаагчдыг хамруулж байна.	100
13	Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хөтөлж байх	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд байгууллагын 26 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулан, албан хаагчдад танилцуулснаас 24 албан хаагч мэдээллээ баталгаажуулж,	100

		албан хаагч түр чөлөөтэй тул баталгаажуулаагүй байна. Мөн 24 албан тушаалын тодорхойлолтыг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд бүрэн оруулан Төрийн албаны зөвлөлөөр баталгаажуулсан. Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо цахим системд албан хаагчдын мэдээллийг тухай бүр нь шинэчлэн оруулсан бөгөөд нийт 120 гаруй удаа хандалт хийсэн байна.	
14	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам" 17 дугаар тогтоолын дагуу Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэл хөтлөх, Төрийн албанаас чөлөөлөгдөн сул орон тоо гарсан тохиолдолд энэ тухай мэдээллийг 7 хоногт төрийн албаны салбар зөвлөлд мэдэгдэж байх	Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчийн сул орон тооны захиалгыг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсний дагуу тусгай шалгалтыг зохион байгуулан 2024 оны 96 дугаар тогтоолоор нэр дэвшүүлэн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөрт газрын даргын тушаалаар Усан хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчийг томилсон. Мөн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс тэтгэвэртээ гарсан тул сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлсний дагуу тусгай шалгалтыг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдөр зохион байгуулсан. Тусгай шалгалтад тэнцсэн иргэний нэр дэвшүүлсэн тогтоол ирээгүй байна.	100
15	Засгийн газрын 11-11 төвөөс 7 гомдол, 70353511 төвд 509 өргөдөл, гомдол ирснээс 25 нь хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна. Иймд өргөдөл, гомдлыг яаралтай шийдвэрлэж, иргэний өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийгдсэн болон шийдвэрлэлтийн холбогдох баримт бичгийг цахим сан болон архивд хавсаргах	Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын гомдол хүлээн авах утас болох 70353511 дугаарт газартай холбоотой 151, барилгатай холбоотой 137, чиг үүргийн дагуу шилжүүлсэн 14 өргөдөл бүртгэгдсэнийг иргэнд хариу өгч хаасан байна. Засгийн Газрын 11-11 төвөөс нийт 8 өргөдөл ирсэн ба Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газартай холбоотой 1 гомдол байсныг удирдлагын цохолтын дагуу тухай байгууллагад шилжүүлсэн, 7 өргөдөлд нь иргэнд хариу ажлын 3-5 хоногт багтаан тайлбар өгсөн. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь 94,3%-тай байна. Өргөдөл гомдлын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт улирал бүр албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100
16	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах	Тайлант хугацаанд 1860 өргөдөл, гомдол хүлээн авч бүртгэл үйлдэн мэргэжилтэн бүрд хүргүүлэн ажилласан. Шийдвэрлэж хариу өгсөн 1755 өргөдөл, хуулийн хугацаа болоогүй 105 өргөдөл байна. 1 хоногт	100

		шийдвэрлэсэн 509, 7 хоногт шийдвэрлэсэн 548, 14 хоногт шийдвэрлэсэн 315, 30 хоногт шийдвэрлэсэн 458, 30-аас дээш хоногт шийдвэрлэсэн 30 өргөдөл гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног байна.	
17	Цаашид өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийсэн ажлын тайланг ирүүлж иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, өргөдөл, гомдлыг бууруулахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган ажиллах	Өргөдөл гомдлын мэдээг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 161 дүгээр албан бичгээр, 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 471 дүгээр албан бичгээр, 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 742 дугаар албан бичгээр тус тус аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. 4 дүгээр улирлын тайлан мэдээг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор гарган хүргүүлэхээр ажиллаж байна.	100
18	Мэдээллүүдийг хуульд заасны дагуу бүрэн байршуулах	Байгууллагын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудсанд 71 мэдээ мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт зэрэг 47 мэдээллийг хариуцсан албан хаагчтай хамтран оруулсан.	100
19	Байршуулсан мэдээллийг тогтмол шинэчлэх	МУ-ын Засгийн газраас төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэгтгэн e-mongolia цахим хуудсанд нэвтрүүлсэн. Байгууллагын https://e-mongolia.mn/org/erdenetgazar цахим хуудсанд мэдээллийг шинэчлэн оруулж байна.	100
20	Сайтын үйл ажиллагаа болон мэдээлэл байршуулах ажилтныг үүрэгжүүлэх	Сайтын үйл ажиллагаа болон мэдээлэл байршуулах ажилтнаар мэдээллийн технологийн мэргэжилтнийг үүрэгжүүлэн ажиллаж байна.	100
21	Мэдээллийн ил тод байдалд байнгын хяналт тавьж ажиллах	Нийтийн мэдээллийг ил тод байдлын хуулийн дагуу байгууллагын холбогдох 65 мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудсанд оруулж 94.7% үнэлэгдсэн байна	100
22	Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах	2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж авсан. Орлого бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмж, үр дүнгийн урамшуулал давхардуулан олгохгүй байх албан шаардлагыг 100% биелүүлэн ажилласан. Зөвлөмжийн биелэлтийг fas.audit.mn цахим хуудсанд нотлох баримтыг хавсарган 1 дүгээр улирал, 3 дугаар улирлын байдлаар оруулан ажилласан.	100
23	Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж төсвийг хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулах	Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх нийт мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, тайлагнаж байна. Шилэн дансны сайтад үйл	

		ажиллагаа, худалдан авалт, хүний нөөц, төсөв санхүүгийн нийт 28 үзүүлэлтийг сар бүр-4, хагас жил бүр-4, жил бүр-11, тухай бүр-9 үзүүлэлтийг сар бүр шинэчлэн, зохих хугацаанд нь байршуулан шинэчлэн ажилласан.	
24	Үнэлгээний дүнг тооцож ажиллах, товч тодорхой байх, Нотолгоонд суурилсан байх, Шалгуур үзүүлэлт тодорхой хүрэх түвшиндээ хүрсэн эсэх, иж бүрэн байх, Тайлан хамгаалалт хийгдсэн эсэх зэрэг үзүүлэлтүүдийн дүнгийн дунджаар үнэлгээг хийх	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвараар байгууллагын төрийн захиргааны 21 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан бөгөөд тус тушаалын 6 дугаар хавсралтаар хагас, бүтэн жилийн тайланг, 8 дугаар хавсралтаар батлагдсан үнэлгээний хуудсаар үнэлж улирал бүр үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон Мөн төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулан биелэлтийг тооцон улирал бүр үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.	100
25	Шийдвэр гаргах үйл явцыг тодорхой шат дараалалтай болгож, хууль зүйн үндэслэл, утга найруулга, албан хэрэг хөтлөлтийн хувьд хянаж, хуульд нийцүүлж гаргахад анхаарах шаардлагатай байна.	Төрийн байгууллагын оффисоор албан бичгээ төлөвлөн холбогдох албан хаагчаас санал авч гаргаж байна. Тайлант хугацаанд нийт 1201 бичиг хүлээн авч бүртгэл үйлдэн мэргэжилтэн бүрд хүргүүлэн ажилласан. Бүрэн шийдвэрлэж хаасан албан бичиг 1168, хуулийн хугацаанд судлагдаж байгаа 33 албан бичиг ирсэн. Хугацаатай албан бичгийг тухай бүрд шийдвэрлэх хариуг албан бичгээр хүргүүлсэн. Ирсэн бичиг шийдвэрлэлтийн хувь 97,3%-тай байна. Тайлант хугацаанд 1860 өргөдөл, гомдол хүлээн авч бүртгэл үйлдэн мэргэжилтэн бүрд хүргүүлэн ажилласан. Шийдвэрлэж хариу өгсөн 1755 өргөдөл, хуулийн хугацаа болоогүй 105 өргөдөл байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын гомдол хүлээн авах утас болох 70353511 дугаарт газартай холбоотой 151, барилгатай холбоотой 137, чиг үүргийн дагуу шилжүүлсэн 14 өргөдөл бүртгэгдсэнийг иргэнд хариу өгч хаасан байна. Засгийн Газрын 11-11 төвөөс нийт 8 өргөдөл ирсэн ба Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газартай холбоотой 1 гомдол байсныг удирдлагын цохолтын дагуу тухай байгууллагад шилжүүлсэн, 7 өргөдөлд нь иргэнд хариу тайлбар өгсөн. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь 94,3%-тай байна. Өргөдөл гомдлын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт улирал бүр албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100

		-Тайлант хугацаанд нийт 990 бичиг төлөвлөж илгээсэн байна. Төрийн байгууллагаас 385 хугацаатай албан бичиг ирснийг хугацаанд мэдээллийг гарган хүргүүлсэн. Мөн ирсэн өргөдөл гомдлоос 299 иргэн, ААНБ-д хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлэн ажилласан.	
26	Үүрэг даалгаврын бүртгэл хөтлөх, цахим санд биелэлтийг хугацаандаа бүрэн оруулж байх, холбогдох мэргэжилтнээс биелэлтийг нягталж, тодруулж программд оруулж байх	И-оффисс цахим системээр 2025 оны байдлаар Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс 87 үүрэг даалгавар, ЗДТГ-ын албан хаагчдын хурлаас 37 үүрэг даалгавар тус тус өгөгдсөнийг хугацаанд нь биелэлтийг оруулсан. Газрын даргын шуурхай хуралдаанаас өгөгдсөн 80 үүрэг даалгаврыг И-оффисс цахим системд оруулан биелэлтийн хянан ажиллаж байна.	100
27	Үүрэг даалгаврын биелэлт хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзэнгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаарх мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффисс программын дотоод эмайлаар мэдэгдэж байх	Дээрх зөвлөмжийн дагуу Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Жавхлантөгсөд мэдэгдэж цааш нь уламжилж байхаар болсон.	100
			100

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН. АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.ДҮҮРЭНЖАРГАЛ